

ДОРНОД АЙМГИЙН ХЭМЖЭЭНД 2020 ОНЫ 4 ДҮГЭЭР САРД БҮРТГЭГДСЭН ГЭМТ  
ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН ГАРАЛТ, ТҮҮНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ, АНХААРАХ  
АСУУДЛУУДЫН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

2020.05.01

Хэрлэн сум.

**НЭГ. ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ**

Аймгийн хэмжээнд 2020 оны 4 дүгээр сард 97 холбогдогчтой, 603.9 төгрөгийн хохиролтой, 219 гэмт хэрэг бүртгэгдэж, 56 хэргээр буюу 20.3 хувиар урьд оны мөн үеэс буурчээ. Гэмт хэргийн илрүүлэлт 25.3 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.1 хувиар буурсан байна. Гэмт хэргийн улмаас 11 хүн нас барж, 54 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад нас барсан хүн 11 буюу 50 хувиар, гэмтсэн хүний тоо 19 буюу 26 хувиар тус тус буурсан байна. Иргэд аж ахуйн нэгж байгууллагад учирсан хохирлын 104.4 төгрөг буюу 17.2 хувийг нөхөн төлүүлжээ.

**Гэмт хэргийн гаралт:**-Хэрлэн сумын 4, 5, 8,10,11 дүгээр багууд, Сэргэлэн, Халх гол, Баяндун сумдад өсч,

-Хэрлэн сумын 1,2,3,6,7,9 дүгээр багууд, Баян-Уул, Дашбалбар, Гурванзагал, Цагаан-Овоо, Баянтүмэн, Булган, Матад сумдад буурч, Чулуунхороот, Чойбалсан сумдууд ижил түвшинд, Хөлөнбуйр суманд гэмт хэрэг бүртгэгдээгүй байна.

**Үйлдэгдсэн байдлаар:** - Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 52 бүртгэгдэж 18 буюу 52.9 хувиар, эмэгтэй хүн оролцсон гэмт хэрэг 20 бүртгэгдэж 6 буюу 42.8 хувиар, урьд ял шийтгэгдсэн хүмүүсээс дахин гэмт хэрэгт 34 хүн холбогдсон нь 34 дахин хувиар тус тус өсч,

Бүлэглэн гүйцэтгэсэн гэмт хэрэг 9 бүртгэгдэж 4 буюу 30.7 хувиар, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 8 бүртгэгдэж 4 буюу 33.3 хувиар буурч,

Хүүхэд оролцсон, галт зэвсэгээр үйлдэгдсэн, гадаадын иргэн оролцсон гэмт хэргүүд тус тус бүртгэгдээгүй байна.

**Үйлдэгдсэн газраар:** - Байгууллага аж ахуй нэгжид үйлдэгдсэн гэмт хэрэг 8 бүртгэгдэж 1 буюу 14.2 хувиар өсч,

Гэр, орон сууцанд үйлдэгдсэн гэмт хэрэг 73 бүртгэгдэж 2 буюу 2.6%, гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг 13 бүртгэгдэж 13 буюу 50%, Олон нийтийн газарт үйлдэгдсэн гэмт хэрэг 15 бүртгэгдэж 1 буюу 6.2%, авто замд үйлдэгдсэн гэмт хэрэг 6 бүртгэгдэж 9 буюу 60 %, төрийн байгууллагад үйлдэгдсэн гэмт хэрэг 6 бүртгэгдэж 6 буюу 50%, хөдөө хээр үйлдэгдсэн гэмт хэрэг 36 бүртгэгдэж 3 буюу 7.6%, бэлчээрт үйлдэгдсэн гэмт хэрэг 15 бүртгэгдэж 11 буюу 42.3 хувиар , хөдөө хээрт үйлдэгдсэн гэмт хэрэг 21 бүртгэгдэж 6 буюу 22.2 хувиар тус тус буурсан байна.

**Хэргийн төрлөөр:** -Бэлгийн эрх, чөлөө халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 11 бүртгэгдэж 4 буюу 57.1%, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 11 бүртгэгдэж 10 буюу 1 дахин, Халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг 6 бүртгэгдэж 5 буюу 5 дахин, Залилах гэмт хэрэг 28 бүртгэгдэж 9 буюу 47.3%, Хөрөнгө завших гэмт хэрэг 5 бүртгэгдэж 4 буюу 4 дахин, хууль бусаар мод бэлтгэх гэмт хэрэг 4 бүртгэгдэж 4 буюу 4 дахин хувиар тус тус өсч,

Хүнийг алах гэмт хэрэг 1 бүртгэгдэж 2 буюу 66.6%, Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 48 бүртгэгдэж 12 буюу 20%, хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх гэмт хэрэг 6 бүртгэгдэж 7 буюу 53.8%, дээрэмдэх гэмт хэрэг 1 бүртгэгдэж 2 буюу 66.6%, Гээгдэл эд зүйл, алдуул мал завших гэмт хэрэг 2 бүртгэгдэж 6 буюу 75%, Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэрэг 1 бүртгэгдэж 2 буюу 66.6%, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг 2 бүртгэгдэж 1 буюу 33.3%, Авлигын эсрэг гэмт хэрэг 1 бүртгэгдэж 2 буюу 66.6%, Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 1 бүртгэгдэж 1 буюу 50%, хууль бусаар ашигт малтмал олборлох гэмт хэрэг 3 бүртгэгдэж 1 буюу 25%, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт 8 бүртгэгдэж 7 буюу 46.6 %, бусад төрлийн гэмт хэрэг 4 бүртгэгдэж 1 буюу 20 хувиар тус тус буурчээ.

Хүний амь насыг болгоомжгүй хохироох, эрүүл мэндийн эсрэг, хүүхдийн эсрэг, үндэсний аюулгүй байдлын эсрэг, олон нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулах, хууль бусаар ан агнах, цэргийн албаны эсрэг гэмт хэргүүд бүртгэгдээгүй байна.

Хулгайлах гэмт хэрэг 40 бүртгэгдсэн нь нийт гэмт хэргийн 18.2 хувийг эзлэж байгаа ба үүнээс: хувийн өмчийг хулгайлах 37 бүртгэгдэж 7 буюу 15.9 %, малын хулгайн гэмт хэрэг 46 бүртгэгдэж 20 буюу 30.3 хувиар тус тус буурсан байна.

**Үйлдэгдсэн цаг хугацаагаар нь:** 22-06 цагийн хооронд 67 гэмт хэрэг бүртгэгдсэн нь 30.5 %, 06-14 цагийн хооронд 40 гэмт хэрэг бүртгэгдсэн нь 18.2%, 14-19 цагийн хооронд 65 гэмт хэрэг бүртгэгдсэн нь 29.6%, 19-22 цагийн хооронд 47 гэмт хэрэг бүртгэгдсэн нь нийт гэмт хэргийн 21.4%-ийг эзэлж байна.

Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 29 буюу 13.2 хувь нь Баасан, Лхагва гарагт 34 буюу 15.5% Даваа гарагт 29 буюу 13.2%, Мягмар гарагт 33 буюу 15%, Пүрэв гаригт 26 буюу 11.8% Бямба гарагт 47 буюу 21.4%, Ням гарагт 21 буюу 9.5 хувь тус тус үйлдэгджээ.

**Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийг байршлаар нь:** Хэрлэн сумын 6-р багт 9 буюу 17.3%, 1,3,9-р багууд, Дашбалбар, Сэргэлэн, Цагаан-Овоо, Баян-Уул сумдад тус бүр 2 буюу 3.8%, 8,11-р баг, Чулуунхороот, Баяндун, Булган, Гурванзагал сумдад тус бүр 1 буюу 1.9%, 2-р баг,10,4-р багт тус бүр 4 буюу 7.6%,Матад, Чойбалсан сумдад тус бүр 3 буюу 5.7%,7-р багт 6 буюу 11.5 хувиар бүртгэгджээ.

### **ХОЁР. ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ**

Аймгийн хэмжээнд 2020 оны 4 дүгээр сард 6346 зөрчил илрүүлсэн нь 688 зөрчлөөр буюу урьд оны мөн үеэс 12.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Нийт 5850 иргэнийг 235151.0 төгрөгөөр торгож, 211 жолоочийг торгож-тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасч, 40 хүнийг захиргааны журмаар /үүнээс: 30 буюу 75 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 10 буюу 25 хувь нь согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон/ баривчлуулан шийдвэрлэжээ. Согтууруулах ундаа хэрэглэн зөрчил гаргасан 1703 иргэнийг эрүүлжүүлсэн нь 257 буюу 17.7 %-иар өссөн байна.

#### **Зөрчлийн үйлдэгдсэн цаг хугацаа, гарагийг нийт зөрчилд эзлэх хувиар:**

- |                                   |                                |
|-----------------------------------|--------------------------------|
| - Ням гарагт 548 буюу 8.6 %,      | - Лхагва гарагт 955 буюу 15%   |
| - Баасан гарагт 1178 буюу 18.5 %, | - Даваа гарагт 857 буюу 13.5%, |
| - Пүрэв гарагт 1016 буюу 16%,     | - Бямба гарагт 778 буюу 12.2%, |
| - Мягмар гарагт 1014 буюу 15.9%,  |                                |
| - 13-18 цагт 2594 буюу 40.8%,     | - 19-24 цагт 2330 буюу 36.7%,  |

- 06-12 цагт 1237 буюу 19.4 %

- 01-05 цагт 185 буюу 2.9 %.

Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн үедээ зөрчил гарган 1703 иргэн саатуулагджээ. Үүний 109 буюу 6.4% нь эмэгтэй хүн эзлэж байна.

#### **нийгмийн байдлаар нь:**

- Ажилгүй 1686 буюу 99%
- Хувийн хэвшлийн байгууллагын ажилтан 2 буюу 0.1 %
- Хувиараа хөдөлмөр эрхлэгч 4 буюу 0.2 %
- Төрийн албан хаагч 2 буюу 0.1 %
- Бусад 9 буюу 0.5 %-г эзэлж байна.

#### **Эрүүлжүүлэгдсэн шалтгаанаар нь:**

- Бусдын амгалан тайван байдлыг алдагдуулсан **1412 буюу 82.9%**
- Гэмт хэрэг, зөрчилд холбогдсон 108 буюу 6.3 %
- Тээврийн хэрэгсэл согтуугаар жолоодсон 57 буюу 3.3%
- Хаана байгаага, очих газраа мэдэхгүй болсон 109 буюу 6.4 %
- Гэмт хэрэг зөрчилд өртөж болзошгүй 17 буюу 0.9 %

#### **Эрүүлжүүлэгдсэн газраар нь:**

- **Гэр, орон сууцнаас 1272 буюу 74:6 %**
- Гудамж талбайгаас 195 буюу 11.4 %
- Байгууллага, аж ахуйн нэгжээс 37 буюу 2.1 %
- Баар, цэнгээний газраас 21 буюу 1.2 %
- Зочид буудлаас 24 буюу 1.4 %.
- Бусад 154 буюу 9 % нь эрүүлжүүлэгджээ.

### **ГУРАВ. ДҮГНЭЛТ**

1. Бүртгэгдсэн гэмт хэргийн 23.7%, зөрчлийн 6.6%-ийг согтуугаар, гэмт хэргийн 1.1 %, зөрчлийн 1.4%-ийг гэр бүл, хүчирхийллийн улмаас үйлдэгджээ.

2. Нийт гэмт хэргийн 30.5 хувь нь 22-06 цагт, зөрчлийн 40.8% нь 13-18 цагт тус тус бүртгэгдэж, гэмт хэргийн 21.4% нь Бямба, зөрчлийн 18.5% нь тус бүр Баасан гаригт үйлдэгджээ.

3. Гэмт хэргийн 33.3%, зөрчлийн 1.5%, саатуулсан хүний 74.6% нь гэр, орон сууцанд, ахуйн хүрээнд үйлдэгдэж байгаа нь хэрэг, зөрчлийн дийлэнх хувийг эзэлж байна.

4. Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн 25 буюу 48 % нь хүний эрүүл мэндэд хохирол учруулах гэмт хэрэг, эрүүлжүүлэгдсэн хүний 82.9%-ийг бусдын амгалан тайван байдлыг алдагдуулсан зөрчил эзэлж байгаа ба, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн зөрчлийн 1.1 хувь нь согтуугаар үйлдэгджээ.

5 Бэлгийн эрх, чөлөө халдашгүй байдлын эсрэг, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх Халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг, Залилах, Хөрөнгө завших, хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргүүд өссөн үзүүлэлттэй байна.

### **ДӨРӨВ: ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ**

1. Аймгийн хэмжээнд залилах гэмт хэрэг 28 бүртгэгдэж 9 буюу 47.3 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа нь энэ төрлийн гэмт хэрэг цаашид өсөх хандлагатай байгаа тул Мөрдөн байцаах, Хэрэг бүртгэх, Эрүүгийн цагдаагийн тасгаас нэгдсэн болон тусгай арга хэмжээг зохион явуулж үр дүнг тооцож ажиллах.

2. Энэ оны 4 дүгээр сарын байдлаар 219 эрүүгийн хэрэг бүртгэгдэж, илрээгүй 124 эрүүгийн хэрэг ажиллагаанд байна. Хэргийн илрүүлэлт 25.3 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.1 хувиар буурсан үзүүлэлттэй байгаа ба улсын хэмжээнд 20 дугаар байр эзэлсэн байна. Иймд мөрдөн шалгах эрх бүхий алба хаагч нар ажиллагаанд байгаа хэргүүдийг илрүүлэх, хэргийн илрүүлэлтийг ахиулах чиглэлээр тодорхой төрлийн ажлыг зохион байгуулж ажиллах.
3. Бүртгэгдсэн гэмт хэргийн 73 буюу 33.3 хувь нь гэр орон сууцанд үйлдэгдэж байх тул баг, сум хариуцсан хэсгийн төлөөлөгч, хэсгийн байцаагч нар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй оновчтой зохион байгуулах./Зөвхөн зөрчил шалган шийдвэрлэх ажлыг хийх биш хариуцсан багт урьдчилан сэргийлэх ажлыг зохион явуулах шаардлагатай/
4. Эрхийн үнэмлэхгүй согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон үедээ замын хөдөлгөөнд оролцож зөрчил гаргасан этгээд баривчлах шийтгэл оногдуулсан зөрчил энэ оны 4 дүгээр сарын байдлаар 10 байгаа нь өмнө оны мөн үетэй харьцуулахад 52 буюу 86.7 хувиар буурсан улсын хэмжээнд 21 дүгээр байр эзэлсэн байна. /ЗЦТ-ийн зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий алба хаагчид анхаарах, тасгийн дарга, ахлах байцаагч нар хяналт тавьж ажиллах/
5. Урьд өмнө нь ял шийтгэгдсэн хүмүүсээс дахин гэмт хэрэг үйлдсэн гэмт хэрэг 34 бүртгэгдэж 33 буюу 3 дахин өссөн үзүүлэлттэй байгаа тул баг, сум хариуцсан хэсгий төлөөлөгч, хэсгийн байцаагч нар дээрх этгээдүүдэд тавих хяналтыг сайжруулах.
6. Баг хариуцсан хэсгийн байцаагч нар тухайн баг дээр үйлдэгдсэн гэмт хэргийг илрүүлэх чиглэлээр санаачлагатай ажиллахгүй туйлын хангалтгүй байна.
7. Хамтарсан багийн ажлыг эрчимжүүлэх, объект, субъектын судалгааг баяжуулах, эзэн холбогдогч нь илрээгүй хэргийг илрүүлэх чиглэлээр ажил зохион байгуулах.
8. Хагас жилийн тайлан мэдээ гарахад 1 сарын хугацаа үлдсэн тул гэмт хэргийн илрүүлэлтийг ахиулах чиглэлээр Халхгол, Хөлөнбуйр, Баян-Уул сумдуудын Цагдаагийн тасаг, ЭЦТ, МБТ, ХБТ, НХЖХТ, ЗЦТ-ийн дарга нар нэгдсэн болон тусгай арга хэмжээг зохион явуулж үр дүнг тооцож ажиллах шаардлагатай байна.

Та бүхний ажилд амжилт хүсье.

ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ЦАГДААГИЙН ГАЗАР